



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ



Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаяг эсхүл дээрх QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ	2
НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:	5
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ	7
2.1. Нэгдсэн төсвийн орлого:	8
2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага:	10
2.3. Төсвийн тэнцэл:	11
ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА	12
3.1. Гадаад худалдааны эргэлт:	12
3.2. Экспорт:	13
3.3. Импорт:	15
ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	16
4.1. Мөнгөний нийлүүлэлт:	16
4.2. Гадаад валютын албан нөөц:	17
4.3. Төлбөрийн тэнцэл:	18
ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ.	18
5.1. Хүн ам, ажил эрхлэлт:	18
5.2. Ажилгүйдэл:	19



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ



КОВИД-19 вирусын тархалт үргэлжилж, гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл өөрчлөгдсөнөөр эдийн засгийн өсөлт 2020 онд огцом саарч макро түвшний голлох үзүүлэлтүүд буурч эдийн засаг агшиж байсан бол 2021 оны эхний хагас жилийн байдлаар эдийн засаг сэргэж өсөлт үргэлжилж байна.

Эдийн засаг 6.3 хувийн өсөлттэй гарлаа. ДНБ-ий бодит өсөлт 2017-2019 онуудад дунджаар 6.3 хувийн өсөлттэй байсан бол 2020 оны нэгдүгээр улиралд ДНБ огцом буурч -10.7 хувьтай байсан нь 2016 оноос хойш хамгийн доод хэмжээндээ хүрчээ. 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар 15.7 хувиар өсөж эхэлсэн эдийн засаг 2021 оны хоёрдугаар улирлын байдлаар 6.3 хувийн өсөлттэй гарлаа.

Нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал буурчээ. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2021 оны эхний хагас жилд 1,069.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Алдагдлын хэмжээ өмнөх оны мөн үеэс 1,128.5 (-51.3%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Төсвийн орлогын хувьд: Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 6,428.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 6.4 хувь буюу 386.2 тэрбумаар төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны мөн үеэс 2,328.4 тэрбум төгрөг буюу 56.8 хувиар нэмэгдсэн байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 8,570.0 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 87.5 хувийг зарцуулж 1,071.8 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 1,199.9 тэрбум төгрөг буюу 19.0 хувиар өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч өмнөх оны мөн үеэс өсжээ. Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 7,372.4 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 39.4 хувь буюу 2,084.1 сая ам.доллараар өссөн ба гадаад худалдааны тэнцэл 850.2 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Мөнгөний нийлүүлэлт өслөө. Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) өмнөх оны мөн үеэс 29.8 хувиар өсч 27.6 их наяд төгрөгт хүрсэн байна.

Хэрэглээний үнийн индекс өссөн. Хэрэглээний үнийн улсын индекс 2021 оны 6 дугаар сарын байдлаар сарын инфляц 0.7 хувь, жилийн 6.6 хувь байна. Өмнөх оны мөн үеэс 3.8 пунктээр өссөн байна.

Гадаад валютын нөөц нэмэгдлээ. Нийт албан нөөцийн хэмжээ 2021 оны хоёрдугаар улирлын байдлаар 4,731.8 сая ам.долларт хүрсэн байна. Гадаад валютын албан нөөц өмнөх оны мөн үеэс 1,175.9 сая ам.доллар буюу 33.0 хувиар нэмэгдсэн байна.

Төлбөрийн тэнцэл алдагдалтай гарлаа. 2021 оны хоёрдугаар улирлын байдлаар урсгал тэнцэл 648.0 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 334.6 сая ам.долларын илүүдэлтэй, төлбөрийн тэнцэл 225.0 сая ам.долларын алдагдалтай гарч, өнгөрсөн оны мөн үеийн


гүйцэтгэлээс 676.8 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Үнэт цаасны арилжаа өсжээ. Үнэт цаасны арилжаагаар 2021 оны эхний хагас жилд 619.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 595.7 (26.3 дахин их) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтвортой байна. 2021 оны эхний хагас жилийн байдлаар Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 2,848.7 төгрөг болж өмнөх сар болон оны эхнээс тогтвортой байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 441.09 төгрөг болж өмнөх сараас 1.5 хувиар чангарч, оны эхнээс 1.1 хувиар суларсан байна.

Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн хэмжээ өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны эхний хагас жилд 1,189.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 182.7 тэрбум төгрөг буюу 18.1 хувиар өссөн байна. Түүнчлэн банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2021 оны хоёрдугаар улирлын эцэст 2.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 37.1 тэрбум төгрөг буюу 1.9 хувиар өссөн байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС




НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн нь 2017 оны мөн үед 13.1 их наяд, 2018 оны мөн үед 15.0 их наяд, 2019 оны мөн үед 17.6 их наяд, 2020 оны мөн үед 17.1 их наяд төгрөгт хүрч байсан бол 2021 оны хоёрдугаар улирлын гүйцэтгэлээр 19.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.4 их наяд төгрөгөөр буюу 14.2 хувиар өслөө.

График 1. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр /их наяд төгрөг/




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нэрлэсэн ДНБ-ий дүн өсөхөд эцсийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 0.8 их наяд төгрөгөөр буурсан ч, хөрөнгийн хуримтлал 2.0 их наяд төгрөгөөр, цэвэр экспорт 1.2 их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Эцсийн ашиглалтын аргаар: 2021 оны хоёрдугаар улирлын гүйцэтгэлээр 2015 оны зэрэгцүүлэх үнээр ДНБ 12.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.7 их наяд төгрөгөөр буюу 6.3 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

График 2. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2021 оны эхний хагас жилд ДНБ-ий 83.1 хувь эцсийн хэрэглээнд, 38.1 хувь нь хөрөнгийн нийт хуримтлалд, -21.2 хувь нь цэвэр экспортод ногдож байна.

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 2.7 (16.0%) их наяд төгрөгөөр, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 12.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 739.0 (6.3%) тэрбум төгрөгөөр өслөө.

Хүснэгт 1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр /тэрбум төгрөг/

Бүрэлдэхүүн	2017-II	2018-II	2019-II	2020-II	2021-II
ДНБ	13,021.2	15,435.9	17,942.8	16,958.4	19,672.7
Хөдөө аж ахуй ойн аж ахуй загас барилт ан агнуур	1,840.1	2,187.1	2,367.9	2,739.8	2,809.3
Уул уурхай, олборлолт	3,063.6	3,929.5	4,672.4	3,394.6	4,890.3
Боловсруулах үйлдвэрлэл	799.2	909.2	1,013.1	969.0	1,327.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	308.6	371.9	412.4	444.4	495.4
Барилга	259.0	266.0	343.3	363.7	278.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	983.7	1,130.6	1,407.8	1,299.3	1,474.4
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	675.8	777.9	832.9	651.5	646.0
Мэдээлэл, холбоо	216.7	245.0	281.1	304.5	354.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	3,781.4	4,066.1	4,834.0	5,225.5	5,305.3
Бүтээгдэхүүний цэвэр татвар	1,093.0	1,552.7	1,777.9	1,566.1	2,091.7

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2021 оны хоёрдугаар улирлын гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий 36.0 хувийг аж үйлдвэр, 40.0 хувийг үйлчилгээ, 14.0 хувийг хөдөө аж ахуй, үлдсэн 11.0 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар эзэлсэн байна. 2021 оны хоёрдугаар улирлын байдлаар үйлдвэрлэлийн аргаар ДНБ-ийг оны үнээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүтээгдэхүүний цэвэр татвар 33.6 хувиар, аж үйлдвэр 35.2 хувиар, үйлчилгээ 4.0 хувиар, хөдөө аж ахуй 2.5 хувиар тус тус өссөн байна.

График 3. ДНБ-ий хэмжээ, жил бүрийн эхний хагас жилд /их наяд төгрөгөөр/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2011 онд ДНБ-ий бодит өсөлт 17.3 хувь байх үед нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 4,917.1 мянган төгрөгтэй тэнцэж энэ үеэс нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ өсөх хандлагатай байсан. 2019 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр ДНБ-ний өсөлт 5.2 хувьд хүрэх үед нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 11,680.6 мянган төгрөг буюу хамгийн өндөр утгандаа хүрчээ. 2020 онд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ буурч 2019 оны мөн үеэс 1.9 хувь буюу 221.1 мянган төгрөгөөр буурч 11,459.5 мянган төгрөгт хүрсэн байна. ДНБ-ий бодит өсөлт 2011-2016 онуудад тасралтгүй буурч, 2016 оны гуравдугаар улирлын байдлаар -1.4 хувь буюу хамгийн доод цэгтэй хүрсэн. Харин 2017-2019 онуудад дунджаар 6.3 хувийн өсөлттэй байсан бол 2020 оны эхний улиралд ДНБ огцом буурч -10.7 хувьтай тооцоологдсон нь 2016 оноос хойш хамгийн доод хэмжээндээ хүрчээ. 2020 оны эхний хагас жилд -9.7 хувь, гуравдугаар улирлын гүйцэтгэлээр -7.3 хувьтай гарсан бол 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр -5.3 хувьд хүрсэн.

2021 оны нэгдүгээр улирлын байдлаар Монгол Улсын эдийн засаг 15.7 хувиар өсөж эдийн засаг сэргэж эхэлсэн байна.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 96.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

2021 оны хоёрдугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 6,428.7 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 7,498.2 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,069.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 386.2 тэрбум төгрөг буюу төлөвлөснөөс 6.4 хувиар давж биелсэн бол төсвийн нийт зарлага 1,071.8 тэрбум төгрөг буюу 12.5 хувиар төлөвлөснөөс дутуу зарцуулагджээ.

Хүснэгт 2. Монгол Улсын нэгдсэн төсөв /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2021 оны хоёрдугаар улирал		Өөрчлөлт	
	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	6,042.5	6,428.6	386.2	6.4
Нийт зарлага цэвэр зээлийн дүн	8,570.0	7,498.2	1,071.8	-12.5
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-2,527.5	-1,069.5	1458,0	-57.7
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-12.8	-5.4	-7.4	

Эх сурвалж: Сангийн яам

2021 оны хоёрдугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн нь 6,428.6 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 2,328.4 тэрбум төгрөг буюу 56.8 хувиар, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 7,498.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 1,199.9 тэрбум төгрөг буюу 19.1 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн өөрчлөлт, 2017-2021 оны хоёрдугаар улирлын байдлаар /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Хоёрдугаар улирал				Өөрчлөлт (+/-)	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	4,138.0	4,900.4	4,100.2	6,428.6	2,328.4	56.8
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	4,125.1	4,708.2	6,298.2	7,498.1	1,199.9	19.1
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	12.9	192.1	-2,198.0	-1,069.5	1,128.5	-51.3
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	8.3	1.0	-1.3	-5.4		

Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

2021 оны хоёрдугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,069.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, энэ нь өмнөх оны мөн үеэс 1,128.5 тэрбум төгрөгөөр буурсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь 5.4 хувь болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ДНБ-д эзлэх алдагдлын хэмжээ өссөн үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдал 2021 оны хоёрдугаар улирлын гүйцэтгэлээр төлөвлөсөн дүнгээс 1,458.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

2.1 Нэгдсэн төсвийн орлого

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 86.9 хувийг татварын орлого, 13.1 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 6,428.7 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 56.8 хувь буюу 2,328.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 6.4 хувь буюу 386.2 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл Орон нутгийн төсөв 1.6 хувь буюу 30.4 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс дутуу төвлөрсөн бол Улсын төсөв 1.9 хувь буюу 84.5 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын сангийн төсөв 7.9 хувь буюу 89.2 тэрбум, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 0.2 хувь буюу 1.1 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 65.9 хувь буюу 1,830.6 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 8.0 хувь буюу 135.0 тэрбум, нийгмийн даатгалын сангийн орлого 16.6 хувь буюу 173.2 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2.3 дахин буюу 269.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн орлогын 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, төсвийн шатлалаар /тэрбум төгрөгөөр/


Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.	Төлөв.	Гүйц.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,117.4	5,286.8	1,843.0	1,812.6	1,126.3	1,215.5	481.4	482.5
ИРЭЭДҮЙН ӨВ САН	520.5	417.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	72.1	259.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,524.9	4,609.3	1,843.0	1,812.6	1,126.3	1,215.5	481.4	482.5
Татварын орлого	3,877.0	3,845.1	753.8	748.8	855.3	944.5	481.4	482.5
Орлогын албан татвар	1,424.3	1,356.2	502.7	491.0	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	855.3	944.5		
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	105.8	94.7	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,268.5	1,345.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	418.9	396.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	8.9	6.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	445.5	441.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	311.0	299.1	145.3	162.2	0.0	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	647.8	764.3	1,089.2	1,063.8	271.0	271.0	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	329.3	687.4	126.4	111.1	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.6	0.5	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	78.3	49.4	5.2	3.7	271.0	271.0	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	240.2	27.4	957.1	948.5	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

Татварын орлого 5,588.4 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 1.3 хувь буюу 70.8 тэрбум төгрөгөөр давж биелжээ.

Татварын орлогын 33.1 хувийг орлогын албан татвар, 17.8 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.7 хувийг хөрөнгийн албан татвар, 24.1 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 7.1 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 7.9 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 8.2 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

График 4. Татварын орлого /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд татварын орлого 1.3 хувь буюу 70.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь нийгмийн даатгалын орлого, нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад татвар, төлбөр, хураамж тус тус төлөвлөснөөс давж биелсэнтэй холбоотой байна.

Төлөвлөгөөтэй харьцуулахад орлогын албан татвар 78.9 тэрбум төгрөг (4.1 хувь), хөрөнгийн албан татвар 11.1 тэрбум төгрөг (10.5 хувь), онцгой албан татвар 22.8 тэрбум төгрөг (5.4 хувь), тусгай зориулалтын орлого 2.4 тэрбум төгрөг (27.0 хувь), гадаад үйл ажиллагааны орлого 4.1 тэрбум төгрөг (0.9 хувь)-өөр төлөвлөгөөнөөс дутуу гүйцэтгэлтэй гарчээ.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр татварын орлого 1,845.5 тэрбум төгрөг буюу 49.3 хувиар өсөхөд тусгай зориулалтын орлого 1.6 тэрбум (19.5 хувь) төгрөгөөр буурсан ч орлогын албан татвар 928.6 тэрбум (101.0 хувь), нийгмийн даатгалын орлого 208.4 тэрбум (26.5 хувь), хөрөнгийн албан татвар 15.0 тэрбум (18.8 хувь), нэмэгдсэн өртгийн албан татвар 392.2 тэрбум (41.1 хувь), онцгой албан татвар 30.9 тэрбум (8.5 хувь), гадаад үйл ажиллагааны орлого 105.6 тэрбум (31.4 хувь), бусад татвар, төлбөр, хураамж 166.5 тэрбум (56.5 хувь) төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

Татварын бус орлого 840.3 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 482.9 тэрбум төгрөгөөр өссөн бол төлөвлөснөөс 315.3 тэрбум төгрөг буюу 60.1 хувиар давж биелжээ.

Татварын бус орлого давж биелэхэд төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 0.1 тэрбум, гадаад хандив тусламжийн орлого 27.5 тэрбум төгрөгөөр, нийтлэг татварын бус орлогоос навигацийн орлого 27.0 тэрбум, хувьцааны ногдол ашиг 8.6 тэрбум, хүүгийн орлого 6.2 тэрбум, төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн хэдий ч торгуулийн орлого 3.6 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 1.2 тэрбум, газрын тосны орлого 30.6 тэрбум төгрөгөөр, бусад орлого 349.2 тэрбум төгрөгөөр тус тус давж төвлөрсөн нь нөлөөлжээ.

Татварын бус орлогын 95.0 хувийг нийтлэг татварын бус орлого, 4.9 хувийг тусламжийн орлого, 0.05 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийт татварын орлогод эзлэх нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 22.2 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 1.8 хувийг хувьцааны ногдол ашиг, 3.4 хувийг хүүгийн орлого, 5.0 хувийг торгуулийн орлого, 0.2 хувийг түрээсийн орлого, 13.1 хувийг газрын тосны орлого, 4.0 хувийг навигацийн орлого эзэлсэн бол 50.2 хувийг бусад орлого бүрдүүлж байна.

График 5. Татварын бус орлогын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 8,570.0 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 87.5 хувийг зарцуулж 1,071.8 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 1,199.9 тэрбум төгрөг буюу 19.0 хувиар өссөн байна.

Тайлант хугацаанд төлөвлөснөөс Улсын төсвийн зарлага 667.1 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 736.9 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан бол нийгмийн даатгалын сангийн зарлага 59.0 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 31.5 тэрбум төгрөгөөр илүү зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс Улсын төсвийн нийт зарлага 981.3 тэрбум, Нийгмийн даатгалын сангийн зарлага 73.3 тэрбум, Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 319.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулагдсан бол Орон нутгийн төсвийн зарлага 94.5 тэрбум төгрөгөөр буурч зарцуулагдсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 5. Нэгдсэн төсвийн зарлага /тэрбум төгрөгөөр/

НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	ӨО-ны мөн үе	2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэл			
		Төлөв.	Гүйц.	Зөрүү	Хувь
	6,298.3	8,570.0	7,498.2	-1,071.8	87.5
НИЙТ ЗАРЛАГА	6,279.6	8,863.6	7,419.3	-1,444.4	83.7
УРСГАЛ ЗАРДАЛ	5,050.8	7,544.1	6,559.6	-984.5	86.9
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,164.2	2,674.9	2,056.3	-618.6	76.9
ХҮҮ	425.2	480.2	420.1	-60.1	87.5
ТАТААС	376.8	260.3	202.7	-57.6	77.9
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	49.0	43.0	26.0	-17.1	60.3
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	327.9	217.2	176.7	-40.5	81.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,084.5	4,128.7	3,880.5	-248.3	94.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,228.9	1,319.5	859.6	-459.9	65.1
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	18.7	-293.7	78.9	372.6	-26.9

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 19.1 хувь буюу 1,199.9 тэрбум төгрөгөөр өсөхөд урсгал зардал 29.9 хувь буюу 1,508.9 тэрбум, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 60.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Монгол Улсын Макро эдийн засгийн 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэл
Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.2 хувь буюу 5.1 тэрбум төгрөгөөр буурсан бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 12.5 хувь буюу 60.1 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулалттай гарсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 88.4 хувь буюу 6,559.6 тэрбум төгрөг буюу нь урсгал зардал эзэлж байна. Урсгал зардлын 59.2 хувийг урсгал шилжүүлэг, 31.3 хувийг бараа, ажил, үйлчилгээний зардал, 6.4 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.1 хувийг татаас эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 1,508.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: бараа, ажил, үйлчилгээний зардал 107.8 тэрбум, татаас 174.1 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 5.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан ч урсгал шилжүүлэг 1,795.9 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

2.3. Төсвийн тэнцэл

2021 оны хоёрдугаар улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,069.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 5.4 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарсан байна.

Хүснэгт 6. Төсвийн тэнцэл /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жил бүрийн хоёрдугаар улирлын байдлаар					Өөрчлөлт (+/-)	
	2017	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-676.5	12.9	192.1	-2,198.0	-1,069.5	1,128.5	-51.3
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-5.2	8.3	1.0	-1.3	-5.4	6.7	315.0

Эх сурвалж: Сангийн яам

Гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 426.6 тэрбум төгрөг төлсөн бол урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 90.5 тэрбум төгрөг төлөгдсөн байна. Засгийн газар урт болон богино хугацаат дотоод бонд шинээр гаргаагүй, харин 368.7 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл, 285.0 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл шинээр авсан гүйцэтгэлтэй байна.

ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА

3.1. Гадаад худалдааны эргэлт: Гадаад худалдааны нийт бараа эргэлт: Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 7,372.4 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 39.4 хувь буюу 2,084.1 сая ам.доллаар өсөж гадаад худалдааны тэнцэл 850.2 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Хүснэгт 7. Гадаад худалдааны үзүүлэлт /сая ам.доллар/

Үзүүлэлт	6 дугаар сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт /өмнөх оны мөн үеэс/	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	6,340.5	6,832.8	5,288.3	7,372.4	2,084.1	39.4
-Экспорт	3,581.4	3,939.0	2,828.2	4,111.3	1,283.1	45.4
-Импорт	2,759.1	2,893.8	2,460.1	3,261.1	801.0	32.6
Тэнцэл	822.2	1,045.2	368.0	850.2	482.2	131.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 482.2 сая ам.доллаар өсч 850.2 ам.долларын ашигтай гарчээ. Тэнцэл өсөхөд экспортын өсөлт 1,283.1 сая ам.доллар болж импортын өсөлтөөс 850.2 сая ам.доллаар их байгаа нь нөлөөлсөн байна.

Хөрш орнуудтай хийсэн худалдаа: Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл БНХАУ-тай 2021 оны эхний хагас жилд 5.0 тэрбум америк долларын, ОХУ-тай 897.5 сая ам.долларын худалдааг хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 28.0 хувиар, БНХАУ-тай хийсэн худалдаа 68.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 8. Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт /сая ам.доллар/

Улс	Төрөл	6 дугаар сар (өссөн дүнгээр)			Өөрчлөлт (+/-)	
		2019	2020	2021	2021.6/2020.6	
					Дүн	Хувь
БНХАУ	Нийт эргэлт	4,498.3	2,973.2	5,016.3	2,043.1	68.0
	Экспорт	3,566.5	2,113.5	3,706.3	1,592.8	75.0
	Импорт	931.8	859.7	1,310.0	450.3	52.0
	Тэнцэл	2,634.7	1,253.8	2,396.3	1,142.5	91.0
ОХУ	Нийт эргэлт	805.2	699.4	897.5	198.1	28.0
	Экспорт	36.6	24.4	50.0	25.6	105.0
	Импорт	768.6	675.0	847.5	172.5	25.5
	Тэнцэл	(732)	(650.6)	(797.5)	146.9	22.5
Бусад	Нийт эргэлт	1,549.2	1,639.2	1,458.6	180.7	11.9
	Экспорт	335.8	690.3	354.9	335.4	51.4
	Импорт	1,193.3	925.4	1,103.6	178.2	19.2
	Тэнцэл	1,193.3	(235.1)	(748.6)	157.2	(218)

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Импорт өмнөх оны мөн үеэс 801.0 сая ам.доллаар өсөхөд улаан буудайн импорт 41.5 сая ам.доллар, ачааны автомашины импорт 163.0 сая ам.доллар, дизелийн түлш 58.1 сая ам.доллар, суудлын автомашины импорт 24.2 сая ам.доллаар өссөн нь голлон нөлөөлжээ.

Монгол Улсын гадаад худалдаа ОХУ болон бусад орнуудтай алдагдалтай, БНХАУ-тай ашигтай гарсан байна.

3.2. Экспорт:

Экспортын худалдаа 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 4,111.3 сая ам.долларт хүрч, 2019 оны мөн үетэй харьцуулахад 172.3 сая ам.доллар буюу 4.4 хувийн өсөлттэй байна. Харин 2020 оны мөн үеэс 1,283.1 сая ам.доллар буюу 45.4 хувиар өссөн байна. Нийт экспортын 82.4 хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, 17.6 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 3,389.4 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 1,368.8 сая ам.доллар буюу 67.7 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 721.9 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 85.7 сая ам.доллар буюу 10.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 9. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт /сая ам.доллар/

Үзүүлэлт	6 дугаар сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	3,027.0	3,307.5	2,020.6	3,389.4	1,368.8	67.7	82.4
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	554.4	631.5	807.6	721.9	-85.7	-10.6	17.6
Нийт экспорт	3,581.4	3,939.0	2,828.2	4,111.3	1,283.1	45.4	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 10. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	Жил бүрийн нэгдүгээр улирал				Өмнөх оны мөн үеэс	
		2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	733.7	749.2	675.9	614.9	-61.0	-9.0
Нүүрс	сая.тн	18.0	18.0	8.7	9.3	0.6	7.2
Төмрийн хүдэр	сая.тн	3.4	4.1	4.1	4.0	-0.1	-2.3
Цайрын баяжмал	мян.тн	61.6	72.4	66.6	66.7	0.0	0.1
Алт	тн	3.4	4.7	11.0	3.7	-7.3	-66.7
Боловсруулаагүй нефть	сая.баррель	3.3	3.2	1.0	2.9	1.9	200.5
Катодын зэс	мян.тн	7.0	4.6	5.7	5.8	0.0	0.7
Адууны мах	мян.тн	8.9	9.8	2.8	7.1	4.2	150.2
Өлөн гэдэс	тн	214.9	211.7	276.0	292.5	16.5	6.0
Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	51.6	43.7	21.4	5.9	-15.5	-72.5
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	0.3	229.6	28.4	441.4	413.0	1454.2
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	69.6	36.9	35.7	66.2	30.5	85.5
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	89.9	97.1	74.1	63.4	-10.8	-14.5
Самнасан ноолуур	тн	171.4	155.1	104.6	152.8	48.2	46.1
Бохир ноолуур	тн	3,974.1	4,207.6	2,656.7	4,893.2	2,236.5	84.2
Хонины самнаагүй ноос	мян.тн	3.3	4.8	2.7	5.5	2.9	107.2
Жоншны баяжмал	мян.тн	196.0	286.4	313.7	391.0	77.3	24.6

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 11. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого /сая ам.доллар/

Төрөл	6 дугаар сар (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	1,014.0	1,062.4	741.1	1,312.9	571.8	77.2
Нүүрс	1,404.8	1,540.5	690.1	1,017.0	327.0	47.4
Төмрийн хүдэр	156.1	251.8	283.2	550.8	267.6	94.5
Цайрын баяжмал	108.0	107.1	80.1	101.1	21.0	26.3
Алт	144.5	195.9	606.4	218.0	-388.4	-64.0
Боловсруулаагүй нефть	212.4	179.7	34.0	168.4	134.4	395.7
Катодын зэс	46.8	27.3	30.8	50.6	19.9	64.6
Адууны мах	19.5	18.5	5.6	14.6	9.1	163.6
Өлөн гэдэс	3.8	4.3	4.4	6.7	2.3	51.3
Үхэр, адууны боловсруулсан шир	5.7	4.7	2.0	0.7	-1.3	-65.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.01	0.7	0.1	0.7	0.7	1301.3
Хонь, хурганы боловсруулсан арьс	2.0	0.9	0.9	1.3	0.4	49.2
Ямаа, ишигний боловсруулсан арьс	3.4	3.2	2.7	1.8	-0.9	-33.8
Самнасан ноолуур	14.3	14.2	7.7	11.6	3.9	51.6
Бохир ноолуур	187.6	216.1	78.3	197.1	118.8	151.8
Хонины самнаагүй ноос	4.0	7.4	2.8	5.7	2.9	105.6
Жоншны баяжмал	64.3	92.8	75.7	84.8	9.1	12.0
Нийт экспортод эзлэх хувь	94.7%	94.6%	93.5%	91.1%		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Нийт экспортын 31.9 хувийг зэсийн баяжмал, 24.7 хувийг нүүрс, 13.4 хувийг төмрийн хүдэр ба баяжмал, 5.3 хувийг боловсруулаагүй алт, 4.1 хувийг боловсруулаагүй нефть, 2.5 хувийг цайрын хүдэр ба баяжмал, 2.1 хувийг жоншны хүдэр эзэлсэн байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 1,368.8 сая ам.доллар буюу 67.7 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

Нүүрс: 2021 оны эхний хагас жилийн байдлаар 9.3 сая тонн нүүрс экспортлож, 1,017.0 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын орлого 327.0 сая ам.доллаароор буюу 47.4 хувиар өссөн байна. Нэг тонн нүүрсний экспортын дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 37.9 хувиар өссөн болон тоо хэмжээ 1.1 дахин нэмэгдсэн нь нүүрсний экспортын орлогыг өсөхөд нөлөөлжээ.

Зэсийн баяжмал: 2021 оны эхний хагас жилийн байдлаар зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 77.2 хувь буюу 571.8 сая ам.доллаароор нэмэгдэж, 1,312.9 сая ам.долларт хүрсэн байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ 614.9 мянган тонн болж өнгөрсөн оны мөн үеэс 9.0 хувь буюу 61.0 мянган тонноор буурсан боловч экспортын дундаж үнэ нь 94.7 хувиар өссөн байна.

Цайрын баяжмал: 2021 оны эхний хагас жилийн байдлаар цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ 66.7 мянган тоннд хүрч, 101.1 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Цайрын баяжмалын экспортын орлого өмнөх оны мөн үеэс 26.3 хувь буюу 21.0 сая ам.доллаароор өсөхөд цайрын баяжмалын биет хэмжээ 0.1 хувь буюу 0.05 мянган тонноор өссөн боловч 1 тонн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 26.0 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төмрийн хүдэр: 2021 оны эхний хагас жилийн байдлаар төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ 4.0 сая тоннд хүрч, 550.8 сая ам.долларын

Монгол Улсын Макро эдийн засгийн 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэл экспортын орлого олсон байна. Төмрийн хүдрийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 94.5 хувь буюу 267.6 сая ам.доллаар өсөхөд төмрийн хүдрийн биет хэмжээ 2.3 хувь буюу 0.1 сая тонноор буурсан боловч 1 тонн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 99.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

3.3. Импорт

2021 оны эхний хагас жилийн байдлаар импортын хэмжээ 3,261.1 сая ам.доллар болж 2019 оны мөн үетэй харьцуулахад 367.3 сая ам.доллар буюу 12.7 хувиар, 2020 оны мөн үеэс 801.0 сая ам.доллар буюу 32.6 хувиар өсжээ. Нийт импортын 16.9 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 83.1 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Хүснэгт 12. Эрдсийн бүтээгдэхүүний импорт /сая ам.доллар/

Үзүүлэлт	6 дугаар сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	591.1	621.9	485.4	551.9	66.5	13.7	16.9
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	2,168.0	2,271.9	1,974.8	2,709.2	734.4	37.2	83.1
Нийт импорт	2,759.1	2,893.8	2,460.1	3,261.1	801.0	32.6	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Мөнгөний нийлүүлэлт:

Мөнгөний нийлүүлэлт 2021 оны эхний хагас жилийн байдлаар 27.6 их наяд төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 6.2 их наяд төгрөг буюу 29.2 хувиар өссөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд бараг мөнгө 3.9 их наяд төгрөгөөр буюу 22 хувиар өссөн нь нөлөөлжээ. Валютын харилцах 119.6 тэрбум төгрөгөөр буюу 5.1 хувиар, төгрөгийн харилцах 2.1 их наяд төгрөгөөр буюу 74.2 хувиар, төгрөгийн хадгаламж 3.8 их наяд төгрөгөөр буюу 34.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 13. Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жил бүрийн хоёрдугаар улирлын гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-)	
	2019 VI	2020 VI	2021*		2021.06/2020.06	
			V	VI	Дүн	Хувь
Мөнгөний нийлүүлэлт (M2)	20,229.4	21,347.5	26,917.8	27,587.0	129.2	102.5
Бараг мөнгө	16,124.9	17,770.8	21,156.5	21,679.2	122.0	102.5
-Төгрөгийн хадгаламж	10,936.4	11,053.5	14,877.6	14,897.0	134.8	100.1
-Валютын хадгаламж	2,932.8	4,354.3	4,209.6	4,299.6	98.7	102.1
-Валютын харилцах	2,255.7	2,363.0	2,069.4	2,482.6	105.1	120.0
M1 мөнгө	4,104.5	3,576.6	5,761.3	5,907.8	165.2	102.5
Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө	937.1	987.3	1,249.6	1,173.7	118.9	93,9

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 14. Зээлийн өрийн үлдэгдэл /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жил бүрийн хоёрдугаар улирлын гүйцэтгэл			Өөрчлөлт (+/-)	
	2019	2020	2021	2021.03/2020.03	
				Дүн	Хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	18,219.9	17,374.6	19,158.9	1,784.3	10.3
-Хэвийн зээл	15,554.9	14,448.6	16,013.1	1,564.5	10.8
-Хугацаа хэтэрсэн зээл	751.1	1,007.1	1,189.8	182.7	18.1
-Чанаргүй зээл	1,913.9	1,918.9	1,956.0	37.1	1.9
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	10.5	11.0	10.2	0.8	7.3
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	4.1	5.7	6.2	10.2	4.0

Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 6 дугаар сарын эцэст 19.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 898.9 (4.9%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1.8 (10.3%) их наяд төгрөгөөр өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 9.5 (49.7%) их наяд төгрөг нь иргэдийнх байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 6 дугаар сарын эцэст 1.2 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 182.7 (18.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр өсжээ.


Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2021 оны 6 дугаар сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 37.1 (1.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.8 пунктээр буурчээ.

Үнэт цаас: Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2021 оны 2 дугаар улирлын байдлаар гүйлгээ хийгдээгүй бол хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2021 оны 6 дугаар сард 33,021.8 нэгж болж, өмнөх сараас 2,740.7 нэгжээр буурч, өмнөх оны мөн үеэс 1,690.5 нэгжээр өссөн байна.

Валютын ханш: 2021 оны эхний хагас жилийн байдлаар Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 2,848.7 төгрөг болж өмнөх сар болон оны эхнээс тогтвортой байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 441.1 төгрөг болж өмнөх сараас 1.5 хувиар чангарч, оны эхнээс 1.1 хувиар суларсан байна.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 6 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 6.6 хувь, өмнөх оны эцсээс 7.0 хувь, өмнөх сараас 0.7 хувиар өссөн.

График 6. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Эх сурвалж: Монголбанк

4.2. Гадаад валютын албан нөөц:

Нийт албан нөөцийн хэмжээ 2021 оны эхний хагас жилийн байдлаар 4,731.8 сая ам.доллар байна. Гадаад валютын албан нөөц өмнөх оны мөн үеэс 1,176.0 сая ам.доллар буюу 33.0 хувиар нэмэгдсэн байна. Коронавирусын цар тахлын дэгдэлтээс үүдэж 2020 оны эхний хагаст экспорт хурдацтай буурч, Засгийн газрын баталгаатай аж ахуйн нэгжийн бондын төлбөр гадагшаа хийгдэж, урсгал дансны алдагдал өссөн хэдий ч 2020 сүүлийн хагасаас гадаад орчинд эерэг өөрчлөлт гарснаар богино хугацаат гадаад өр төлбөрийг хойшлуулж, доноруудын том дүнтэй санхүүжилт орж ирсэн, Монголбанканд тушаах алтны хэмжээ нэмэгдсэн зэрэг нь гадаад валютын албан нөөцийн хэмжээ өсөхөд нөлөөлжээ.

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2021 оны жилийн хоёрдугаар улирлын эцэст 2.3 тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.2 тонноор өссөн байна. Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж ханш 2021 оны 6 дугаар сард 165,015.2 төгрөг байжээ.

4.3. Төлбөрийн тэнцэл:

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 934.9 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 52.2 (5.9%) сая ам.доллаар өсжээ. Тус өсөлтөд анхдагч орлогын алдагдал өмнөх оны мөн үеэс 499.8 сая ам.доллаар өсөж, 945.6 сая ам.долларт хүрсэн нь голлон нөлөөлсөн байна. Харин урсгал дансны алдагдал 2021 оны 6 дугаар сард 412.4 сая ам.доллар болж, өмнөх сараас 268.9 сая ам.доллаар өсжээ. 2021 оны хоёрдугаар улирлын байдлаар урсгал тэнцэл 648 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 334.57 сая ам.долларын илүүдэлтэй, төлбөрийн тэнцэл 225 сая ам.долларын алдагдалтай гарч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээр 676.8 сая ам.доллаар нэмэгдсэн байна.

Үзүүлэлт	2020		2021*	
	VI	I-VI	VI	I-VI
I. Урсгал данс	85.8	-882.7	-412.4	-934.9
Хөрөнгийн данс	8.7	51.2	7.0	63.6
Санхүүгийн данс	-422.8	-419.2	-68.9	-768.6
Алдаа болон орхигдуулга	-65.6	-266.9	50.7	48.5
Нөөц хөрөнгө	451.8	-679.2	-285.8	54.2

Эх сурвалж: Монголбанк

ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

5.1. Хүн ам, ажил эрхлэлт:

Ажиллах хүчний судалгааны 2021 оны хоёрдугаар улирлын дүнгээр улсын хэмжээнд 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 1,207.0 сая нь ажиллах хүч байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажиллах хүч 61.9 (4.9%) мянгаар буурчээ. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын 71.8 (7.8%) мянга нь боломжит ажиллах хүч (цалин хөлс, орлого олох ажилгүй, сүүлийн 30 хоногт ажил идэвхтэй хайсан эсвэл тухайн 7 хоногтоо ажил хийхэд бэлэн байгаа хүн) байна. Боломжит ажиллах хүчний бүлэг нь тухайн сум, орон нутагт нь ажлын байр бий болох эсвэл ажил хийх нөхцөл нь бүрдвэл хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцож эхлэх, ажиллах хүчний эгнээнд шилжихэд бэлэн байгаа хүн ам юм. Ажиллах хүчний 820.5 (68.0%) мянга нь хот, суурин газарт, 386.5 (32.0%) мянга нь хөдөө орон нутагт амьдарч байгаа бол ажиллах хүчнээс гадуурх хүн амын 726.2 (79.2%) мянга нь хот, суурин газарт, 190.8 (20.8%) мянга нь хөдөө орон нутагт амьдарч байна. Ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 3.0 пунктээр, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 3.7 нэгж хувиар буурсан байна.

Улсын хэмжээнд 2021 оны хоёрдугаар улирлын байдлаар ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 61.9 (4.9%) мянгаар, ажиллах хүчнээс гадуурх хүн амын бүлэг болох боломжит ажиллах хүч 2.0 (2.7%) мянгаар буурч 71.8 мянгад хүрснээр боломжит ажиллах хүч болон ажилгүй хүний нэгдсэн түвшин 1.8 нэгж хувиар нэмэгдэж 13.5 хувь, хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин 1.8 нэгж хувиар нэмэгдэж 13.8 хувьд хүрсэн байна. Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээлд дэх оролцоог авч үзэхэд, 1,207.0 мянга (56.8%) нь ажиллах хүч, 917.0 мянга (43.2%) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.

Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажиллах хүч 61.9 (4.9%) мянгаар буурч, ажиллах хүчнээс гадуурх хүн ам 62.4 (7.3%) мянгаар өссөн байна. Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс буурахад ажиллагчид 79.5 мянга буюу 6.7 хувиар буурч, ажилгүй хүн 17.5 мянга буюу 20.9 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Улсын хэмжээнд 2021 оны эхний хагас жилийн байдлаар 36 334 эх амаржиж, 36 601 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 1 257 (3.3%)-оор, төрсөн хүүхэд 1 268 (3.3%)-аар тус тус буурсан байна.

5.2. Ажилгүйдэл:

Монгол Улсын Макро эдийн засгийн 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэл

Улсын хэмжээнд 2021 оны хоёрдугаар улирлын байдлаар ажилгүй хүн 101.3 мянга байгаагийн 52.9 (52.3%) мянга нь эрэгтэйчүүд, 48.4 (47.7%) мянга нь эмэгтэйчүүд байна. Ажилгүй хүн өмнөх оны мөн үеэс 17.6 (21.0%) мянга, өмнөх улирлаас 0.1 (0.1%) мянгаар өссөн байна. Ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 8.4 хувь байгаа бөгөөд үүнийг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 8.2 хувь, эмэгтэйчүүдийнх 8.6 хувь байна. Хот, суурин газрын хүн амын ажилгүйдлийн түвшин 9.7 хувь буюу улсын дунджаас 1.3 нэгж хувиар дээгүүр, харин хөдөө орон нутагт ажилгүйдлийн түвшин 5.6 хувь байгаа нь улсын дунджаас 2.8 нэгж хувиар доогуур байна. Ажилгүйдлийн түвшинг бүсээр харахад, Баруун бүсэд 10.5 хувь байгаа нь улсын дунджаас 2.1 пунктээр дээгүүр байна. Ажилгүйдлийн түвшинг аймгаар авч үзэхэд Увс, Ховд, Говьсүмбэр, Говь-Алтай, Орхон, Баянхонгор, Дархан-Уул, Баян-Өлгий, Сэлэнгэ аймагт улсын дунджаас 0.2-14.9 нэгж хувиар дээгүүр байна.

Ажилгүй хүмүүсийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, тодорхой мэргэжил эзэмших түвшний буюу техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд болон дээд боловсролтой ажилгүй хүмүүс нийт ажилгүйчүүдийн 64.7 хувь байгаа бол үлдсэн 35.3 хувь нь бүрэн дунд, түүнээс доош болон боловсролгүй иргэд байна. Хөдөлмөрийн насны хүн амд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 52.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.8 нэгж хувиар буурсан байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

